

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ӨМӨНГИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ  
БОЛОН ЭРТ ИРҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫГ  
СУДАЛСАН НЬ

Ц.Уранчимэг<sup>1</sup>, Т.Ганчимэг<sup>2</sup>, Э. Баясгалан<sup>3</sup>, Я.Буянжаргал<sup>4</sup>, Д.Авирмэд<sup>1,5</sup>

<sup>1</sup>Хавдар судлалын үндэсний төв

<sup>2</sup>Токиогийн их сургууль

<sup>3</sup>Улсын клиникийн төв эмнэлэг

<sup>4</sup>Монголын Эх баригч бага эмч нарын нийгэмлэг

<sup>5</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

e-mail:uranchimeg\_ts@cancer-center.gov.mn

### Abstract

#### KNOWLEDGE AND ATTITUDE OF WOMEN ON CERVICAL CANCER RISK FACTORS, PREVENTION AND SCREENING

Uranchimeg.Ts<sup>1</sup>, Ganchimeg.T<sup>2</sup>, Bayasgalan.E<sup>3</sup>,Buyanjargal.Ya<sup>4</sup>, Avirmed.D<sup>1,5</sup>

<sup>1</sup>National Cancer Center of Mongolia

<sup>2</sup>University of Tokyo, Japan

<sup>3</sup>State Clinic Central Hospital

<sup>4</sup>Mongolian Midwife Assistant Doctors' Association

<sup>5</sup>Health Science University of Mongolia

e-mail:uranchimeg\_ts@cancer-center.gov.mn

### Introduction

Cervical cancer is one of the most common types of cancer in women worldwide. It can be prevented by identifying pre-cancer lesions at early stages using Pap smear screening and treating these lesions. Knowledge and attitude on cervical cancer and Pap smear tests are associated with actual participation in cervical cancer screening. Therefore, our study aimed to investigate cervical cancer and Pap smear knowledge and attitudes among Mongolian women.

### Materials and Methods

A total of 671 women aged 30 to 60 years from urban and rural areas participated in the study. The multiple clusters sampling method was used. We examined the relations of socio-demographic characteristics with lack of knowledge and negative attitude towards Pap smear tests by using a multilogistic regression analysis.

### Result

The response rate was 89% (671/750). 62% of the participants correctly answered less than 4 out of 8 questions about cervical cancer risk factors. Also 47,2% and 79,3% of the total number of the women had never heard of Pap Smear and HPV. Only 16,4% of the respondents have some knowledge about them. Almost all (93%) participants agreed that there is a deficiency of information about cancer and its screening.

58% and 28% of respondents said that they would participate in Pap smear tests voluntarily and agree to vaccinate their daughters.

Positive attitude on Pap smear tests was higher among women living in rural areas and those who have had a Pap smear test.

### Conclusions

Cervical cancer and Pap smear knowledge and attitude among the women in Mongolia are low. Having higher education and higher income level did not ensure positive attitude to cervical cancer screening. Strategies for communicating accurate information about cervical cancer, prevention, and detection as well as risk and treatment of cervical cancer are needed.

**Keywords:** cervical cancer, Pap smear, knowledge and attitudes

Pp.151-157, Tables-4, Figure-1, References-9

### Оршил

Дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүдэд тохиолдох нийт хавдрын өвчлөлийн дотор умайн хүзүүний өмөн (УХӨ) 2-рт ордог [1] ба УХӨ-гийн шинэ тохиолдол 2005 онд 500000, нас баралт 260000 байсны 80% орчим нь хөгжиж буй орнуудад тохиолджээ. Эдгээр орнуудад УХӨ-ийн өвчлөл, нас баралт өндөр байгаа шалтгаануудын нэг нь хүн амын дундах эрүүл мэндийн боловсролын түвшин, өмөнгийн талаарх ойлголт болон түүнээс сэргийлэх дадал, хэвшил дутмаг байгаатай холбоотой. УХӨ-гийн өвчлөлийг бууруулах чиглэлээр ямар нэгэн арга хэмжээ хэрэгжүүлэхгүй бол нас баралт ирэх 10 жилд 25%-аар нэмэгдэх боломжтой юм [2]. Иймд УХӨ-гийн өвчлөл, түүнийг эрт илрүүлэх болон ХХВ (хүний хөхөнцөр вирус)-ийн дархлаажуулалтын хөтөлбөр нь дэлхийн олон орны нийгмийн эрүүл мэндийн чухал асуудлын нэг болоод байна.

Хөгжингүй орнуудын хүн амын дунд хийсэн судалгаагаар умайн хүзүүний өмөнгийн талаарх мэдлэг, хандлага сул, ахимаг настай, ганц бие, амьдрал, боловсролын түвшин доогуур, хотоос зайдуу, алслагдсан орон нутагт амьдарч байгаа хүмүүс умайн хүзүүний өмөнг илрүүлэх үзлэгт хамрагдахгүй хоцрох магадлал өндөртэй болохыг тогтоосон байна [3, 4].

УХӨ нь монгол эмэгтэйчүүдийн хавдрын өвчлөлийн бүтцэд хоёрдугаарт ордог бөгөөд 2000-2008 онуудад УХӨ-ийн тохиолдол 100000 эмэгтэйд 6.6-аас 15.5 болж, нас баралт 3.02 –аас 4.0 болж ихэсчээ [5]. Манай оронд 2012 оны 4 сараас эхлэн анх удаа 30-60 насны эмэгтэйчүүдэд УХӨ-г ПАП-ын шинжилгээгээр эрт илрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Иймээс монгол эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний өмөнгийн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг судлан тандах нь манай оронд эрт илрүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Энэхүү судалгааны зорилго нь 30-60 насны Монгол эмэгтэйчүүдийн УХӨ-гийн болон түүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах талын мэдлэг, хандлага, түүнд нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг олж тогтоох байлаа.

### Зорилго

30-60 насны Монгол эмэгтэйчүүдийн умайн хүзүүний өмөнгийн болон түүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах талаарх мэдлэг, хандлага, түүнийд нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг олж тогтооход судалгааны зорилго оршиж байсан. Зорилгоо биелүүлэхэд доорх

зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- 30-60 насны Монгол эмэгтэйчүүдийн дундах УХӨ-гийн талаарх мэдлэг, хандлагын түвшин тогтоох;
- Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах сэдэл болон түүнд нөлөөлж буй шалтгаан, нөхцлийг тогтоох;
- Урьдчилан сэргийлэх үзлэг, эсийн шинжилгээнд хамрагдсан байдлыг тогтооход чиглэгдсэн.

### Материал, арга зүй

Энэхүү нэгэн агшингийн ажиглалт судалгааг 2011 оны 10 сараас 2012 оны 2 сар хүртэлх хугацаанд урьдчилан боловсруулсан асуумж ашиглан судалаагааны үндсэн мэдээллийг цуглуулсан болно. Шаталсан түүврийн аргаар Улаанбаатар хотын 7 дүүрэг, Дорнод, Ховд, Өвөрхангай аймаг тус бүрээс 2 сум нийт 6 сумын 30-60 насны 671 эмэгтэйчүүдийг судалгаанд хамруулсан. Сонгогдсон дүүрэг, сум бүрээс судалгаанд хамрагдах эмэгтэйчүүдийн тоог тус нутаг дэвсгэрт оршин суух 30-60 насны нийт эмэгтэйчүүдийн тоотой харилцан хүн амын тоотой пропорционал байх зарчимд үндэслэн тооцоолсон. Тоон мэдээллийн статистик боловсруулалтыг Stata-12.0 програмыг ашиглан хийв.

### Ёс зүйн зөвшөөрөл

Судалгаа явуулах ёс зүйн зөвшөөрлийг Эрүүл мэндийн яамны ёсзүйн хороогоор хэлэлцүүлцэн батлуулсан ба судалгаанд оролцогчдоос бичгээр зөвшөөрөл авч, зөвшөөрсөн тохиолдолд судалгаанд хамруулсан болно.

### Үр дүн

Тус судалгаанд УБ хотын 7 дүүрэг, Ховд, Дорнод, Өвөрхангай аймгуудаас тус бүр 2 сумын 30-60 насны нийт 15580 эмэгтэйчүүдийг төлөөлүүлэн 750 эмэгтэй сонгогдсноос 671 (89%) нь судалгаанд оролцсон.

Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 42 ( $\pm$  8.1), 82.2% (541) нь гэр бүлтэй эсвэл хамтран амьдрагчтай, 43.7% (286) дээд боловсролтой, 46.6% (313) дундаж орлоготой эмэгтэйчүүд байв. Ажил эрхлэлтийн байдлыг судлан үзэхэд дийлэнх хувь нь эрхэлсэн ажилтай байсны 22.9% (150) нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 18.0% (118) албан хаагч, 16.5% (108) хувийн байгууллагад ажилладаг байв (Table 1).

**Table 1. Assimilation mark of ages and permanent address of women who are 30-60 years old in research work**

City Province	Age classification (%)			
	30-39 ages	40-49 ages	50-60 ages	Total
Ulaanbaatar	174 (57.2)	143 (64.4)	88 (60.7)	405 (60.4)
Khovd	38 (12.5)	29 (13.1)	24 (16.5)	72 (11.1)
Dornod	13 (4.3)	10 (4.5)	9 (6.2)	32 (4.7)
Uvurkhangai	79 (26.0)	40 (18.0)	24 (16.6)	143 (21.9)

**УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг** эрсдэлт хүчин зүйлийн талаарх мэдлэгийг асууж тодруулсан дүнг Хүснэгт 2-т харуулав.  
 30-60 насны эмэгтэйчүүдийн дундах УХӨ-ийн

**Table 2. Knowledge estimation of cervical cancer’s risk factors**

Question	Right (yes)	Answer n (%)
Multiple sexual partners	457	68.1
Sexually transmitted disease	458	68.3
Multiparity	241	35.9
Cigarette (Smoking)	316	47.1
Women who have never had examination of early detection and a PAP smear test	383	57.1
Early onset of sexual intercourse ( $\leq 16$ age)	250	37.3
Who had cervical cancer in your parentage	92	13.7
Women aged more than 50 years	260	38.7

УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлийн 8 асуулт тус бүрт зөв хариулсан тохиолдолд 1 оноогоор үнэлэн хувь хүн бүрийн нийлбэр оноог дүгнэсэн бөгөөд уг нийлбэр онооны дундаж нь 3.7 ( $\pm 2.3$ ) байлаа. Нийт 671 эмэгтэйчүүдийн 415 нь (62%) 0-4 оноо, 79 (11.8%) 7-8 оноотой байв.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 47.2% (317) болон 79.3% (532) нь умайн хүзүүний эсийн шинжилгээ, хүний хөхөнцөр вирусийн талаар мэдэхгүй буюу сонсоогүй, зөвхөн 16.4%

(110) нь дээрх хоёр ухагдахууны талаар мэддэг байлаа.

Умайн хүзүүний эсийн шинжилгээний талаарх мэдлэг бүхий 354 (52.8%) эмэгтэйчүүдийн дундах УХӨ эрт илрүүлэг, эсийн шинжилгээний талаарх мэдлэгийг судлан үзэхэд 67%-аас дээш хувь нь эсийн шинжилгээ хэзээ анх өгөх, түүнчлэн эсийн шинжилгээ өгөх давтамж талаар мэддэггүй нь судалгаагаар харагдав (Table 3).

**Table 3. Knowledge Estimation News of screening of Cervical Cancer and “PAP smear” test**

Questions	Correct answer	n (%)
Can diagnose the cervical cancer early with PAP Smear test	300	84.7
Somebody has no pain when she has the PAP Smear test	173	48.8
When can someone have Pap smear test for the first time?		
Since intercoursing, within 3 years.	48	13.6
Someone is in sexual activity who is more than 21 years old.	81	23.1
The women above 30 years of age.	133	37.8
Frequency of PAP Smear test:		
Someone should have test once in 3 years 30-60 years old.	88	25.29

Судалгаанд хамрагдсан нийт 671 эмэгтэйчүүдийн 21% (139) нь хүний хөхөнцөр вирусийн талаар сонссон ба эдгээр эмэгтэйчүүдийн 41% (57)

уг халдвараас урьдчилан сэргийлэх вакцины талаар мэднэ, 75% (103) нь уг вирусын халдвар нь УХӨ үүсгэдгийг мэднэ гэсэн байв.

УХӨ, түүний урьдал эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээнд сайн дураар хамрагдах байдлыг тодруулахад нийт эмэгтэйчүүдийн 58% (389) нь тийм буюу шууд хамрагдана, 193 (29%) нь эмчээс асууна, харин цөөн хэсэг нь 13% (87) мэдэхгүй, хамрагдахгүй гэж хариулсан.

Хүний хөхөнцөр вирусийн дархлаажуулалтад 11-15 насны охиноо хамруулах эсэхийг судлахад харьцангуй цөөн хувь нь 28% (180) нь тийм буюу шууд хамрагдана, 36% (232) нь мэдэхгүй, 28% (214) нь болгоомжтой хандана гэсэн байв. Нийт оролцогчдын 96% (643) нь УХӨ, түүний урьдал эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээний талаар мэдээлэл олон нийтэд хэрэгтэй байгааг илэрхийлсэн.

#### УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг болон хувь хүний нийгэм, эдийн засгийн байдлын харилцан хамаарлыг судалсан дүн

Энэхүү судалгаанд хамрагдсан 30-60 насны нийт 671 эмэгтэйчүүдийн УХӨ эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэгийг 8 асуулт бүхий асуумжаар судлан дүгнэсэн ба ерөнхий оноо 4 буюу түүнээс бага тохиолдолд мэдлэг хангалтгүй харин 5 болон түүнээс дээш бол хангалттай гэж хуваан үзсэн.

Цаашид УХӨ эрсдэлт хүчин зүйлсийн талаарх хангалтгүй мэдлэг болон хувь хүний нийгэм,

эдийн засгийн байдлын харилцан хамаарлыг судлан, үр дүнг Хүснэгт 4-т харуулав. 50-60 настай, бага болон бүрэн бус боловсролтой, ядуу, хөдөө орон нутагт оршин суудаг, түүнчлэн урьд нь эсийн шинжилгээ өгч байгаагүй, УХӨ-өөр өвдсөн тохиолдол мэдэхгүй эмэгтэйчүүд УХӨ эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг хангалтгүй байна ( $p < 0.05$ ).




Figure 1. Main source of information on the PAP smear and cervical cancer screening.

Харин олон хүчин зүйлийн ложистик регрессийн анализын дүн шинжилгээгээр эмэгтэйчүүдийн дундах мэдлэг дутмаг байдал нь 50-60 насны эмэгтэйчүүд 30-39 настай эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.7 дахин (adjusted OR 1.68, 95% CI 1.02 – 2.69) их, ядуу эмэгтэйчүүд баян эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин (adjusted OR 2.15, 95% CI 1.30 – 3.54) тус тус их байлаа (Хүснэгт 4).

Table 4. Multivariate logistic regression analysis of risk factors

	Not enough knowledge (n=671)			Possible proposal of screening involving (n=354)		
	n	%	Adjusted OR (95% CI)	n	%	Adjusted OR (95% CI)
<b>Age group (y)</b>						
30-39	178	58.5	1	106	68.8	1
40-49	134	60.4	1.06 (0.73 – 1.55)	86	71.7	1.18 (0.67 – 2.09)
50-60	100	71.0	1.68 (1.02 – 2.69)	61	76.2	1.17 (0.59 – 2.35)
<b>Marital status</b>						
single /divorced/widowed	87	66.9	1.02 (0.65 – 1.62)	46	70.9	1.14 (0.57 – 2.27)
Married/living with partner	328	60.6	1	207	58.8	1
<b>Educational status</b>						
<High school	122	76.3	1.06 (0.73 – 1.55)	38	69.1	0.67 (0.30 – 1.48)
High school graduate	129	61.7	1.36 (0.92 – 2.01)	65	69.1	0.96 (0.53 – 1.74)
College graduate	150	52.4	1	147	73.5	1
<b>Economic condition</b>						
Poor	123	78.3	2.15 (1.30 – 3.54)	31	70.4	0.45 (0.16 – 1.48)
Middle	173	55.3	0.71 (0.47 – 1.04)	119	69.2	0.75 (0.43 – 1.30)
Rich	119	59.2	1	103	74.6	1
<b>Permanent address</b>						
City	231	57.0	1	166	66.4	1

Province/soum	184	69.2	1.11 (0.75 – 1.65)	87	83.6	4.37 (2.03 – 9.40)
Have had PAP smear						
Yes	88	55	0.94 (0.62 – 1.43)	118	82.5	2.65 (1.47 – 4.77)
No	327	64	1	135	63.9	1
Has someone had Cervical cancer in family, in friends?						
Yes	11	42.3	0.50 (0.21 – 1.17)	19	86.4	1.56 (0.61 – 8.48)
No	404	62.6	1	234	70.0	1
Knowledge about cervical cancer, its risk factors						
Enough				118	82.5	1
Not enough				135	63.9	1.09 (0.65 – 1.82)

Умайн хүзүүний эсийн шинжилгээний талаар мэднэ буюу сонссон гэх 354 (52.8%) эмэгтэйчүүдийн УХӨ эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах сэдэл болон хувь хүний нийгэм, эдийн засгийн байдал, УХӨ-ийн мэдлэг хоорондын харилцан хамаарлыг судлан үзсэн (Хүснэгт 4).

Хүснэгт 4-өөс харахад хөдөө орон нутагт оршин суудаг, урьд нь эсийн шинжилгээ өгч байсан эмэгтэйчүүд **УХӨ эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах сэдэл** илүү байгаа нь статистик магадлал бүхий ялгаатай байна ( $p < 0.01$ ).

Олон хүчин зүйлийн ложистик регрессийн анализын дүн эмэгтэйчүүдийн дундах **эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах сэдэл** Улаанбаатар хотод оршин суугч эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөө орон нутагт оршин суугчид 4 дахин (adjusted OR 4.37, 95% CI 2.03 – 9.40), урьд нь эсийн шинжилгээ өгч байсан эмэгтэйчүүд уг шинжилгээ өгч байгаагүй эмэгтэйчүүдээс бараг 3 дахин (adjusted OR 2.65, 95% CI 1.47 – 4.77) илүү байгаа нь тогтоогдов. УХӨ эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэгийн байдал нь УХӨ эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдах сэдэлтэй харилцан хамааралгүй байв.

**Хэлцэмж**

Энэхүү судалгаа нь Монгол улсад 30-60 насны эмэгтэйчүүдийн дундах УХӨ-гийн эрсдэлт хүчин зүйлс болон эсийн шинжилгээний талаарх мэдлэг, УХӨ-н эрт илрүүлгийн талаарх хандлагыг тандан судалсан анхдагч судалгаануудын нэг юм.

Судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйн 60.4% нь Улаанбаатар хот, үлдсэн нь хөдөө орон нутаг, 43.7% нь дээд, 31.9% нь бүрэн, 24.4% бага болон бүрэн бус боловсролтой байсан нь судалгааны үр дүн 30-60 насны бүх эмэгтэйг төлөөлж чадахуйц гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан 30-60 насны эмэгтэйчүүдийн УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлс, эсийн шинжилгээний талаар мэдээлэл дутмаг

байлаа. Тухайлбал: эмэгтэйчүүдийн 62% нь УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлийн талаар мэдээлэл дутмаг, 47.2% болон 79.3% нь умайн хүзүүний эсийн шинжилгээ болон хүний хөхөнцөр вирүсийн талаар мэдэхгүй буюу сонсоогүй байсан.

2010 онд хийсэн “Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн умайн хүзүү, хөхний өмөнгийн эрт илрүүлэгт эмэгтэйчүүдийн хандлагыг судалсан чанарын судалгаа”-гаар ч мөн адил умайн хүзүүний хавдрын үүсэх шалтгааны талаар эмэгтэйчүүдийн мэдлэг муу, буруу ойлголт их байсан байна [6].

Монгол эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний эс (ПАП)-ийн шинжилгээ, ХХВ (папиломавирус)-ийн талаарх мэдлэг, эмэгтэйчүүдийн үзлэг, ПАП шинжилгээнд хамрагдах байдал бусад үндэстэнд хийгдсэн судалгаатай харьцуулбал тун бага байв. Австралид нийт эмэгтэйн 4% эсийн шинжилгээний талаар сонсоогүй [7], Малайз [8] болон Америкт [9] папиломавирусийн талаар 55% болон 60% нь сонсоогүй байсан байна. Манай эмэгтэйчүүдийн дунд УХӨ, ПАП шинжилгээ, хүний хөхөнцөр вирүсийн талаар мэдлэг, хандлага дадал маш муу байгаа нь манай оронд эрт илрүүлгийн хөтөлбөр байхгүйгээс гадна хүн амын дундах эрүүд мэндийн боловсрол сул, буруу дадал хэвшилтэй холбоотой юм.

Эмэгтэйчүүд 96% (643) нь УХӨ, түүний урьдал эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээний талаар мэдээлэл олон нийтэд хэрэгтэй, энэхүү мэдээллийг эмч эмнэлгийн ажилтан (86%), телевиз (55%) болон ухуулах хуудас (44%) –аар авбал хүртээмжтэй гэжээ.

Сингапурт хийгдсэн судалгаагаар ПАП шинжилгээний талаар хаанаас олж мэдсэн тухай асуухад нийт эмэгтэйн тал орчим хувь (46,1%) нь эмч, сувилагч, 14% нь хамаатан садан, найзаасаа, мөн эмэгтэйчүүдийн нэлээд хэсэг нь телевиз, радиогоор энэ талын мэдээлэл авсан гэжээ [8].

Иймд УХӨ-ийн урьдчилан сэргийлэлт, ПАП-ийн шинжилгээ, тэр дундаа ХХВ-ийн талаар илүү нарийн мэдээллийг олон нийтэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслийг ашиглан хүргэх нь чухал байна. Мөн эрт илрүүлэг хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад анхан болон 2-р шатлалд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдын оролцоо шаардлагатай байгаа тул тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна.

**УХӨ эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг** дутмаг байдал нь бидний судалгаагаар 50-60 насны эмэгтэйчүүд 30-39 настай эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.7 дахин, бага орлоготой эмэгтэйчүүд баян эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин (adjusted OR 2.15, 95% CI 1.30 – 3.54) илүү байгаа нь тогтоогдсон бол Австралид хийсэн судалгаанд 30-49 насны эмэгтэйчүүдтэй 18-29 нас болон 50-69 насны эмэгтэйчүүдийг харьцуулахад 2.3 болон 2.1 дахин их эмэгтэйчүүд энэ талын мэдлэг дутмаг (ПАП шинжилгээний талаар дуулаагүй) байсан нь бидний судалгааны үр дүнтэй ижил байсан байна.

Манайд хөдөө орон нутагт оршин суудаг, **эсийн шинжилгээний өгч байсан** эмэгтэйчүүд эрт итлрүүлэг **шинжилгээнд хамрагдах сэдэл илүү** байна.

Австралид хийсэн судалгаагаар мөн дээд боловсролтой эмэгтэйчүүдтэй харьцуулбал дунд боловсролтой 1.7, бага боловсролтой 2.4 дахин их эмэгтэйчүүд ПАП шинжилгээ огт өгч байгаагүй байсан [7]. Харин хөдөө орон нутгийн эмэгтэйг хотын эмэгтэйтэй харьцуулахад 2 дахин олон эмэгтэйчүүд ПАП шинжилгээний талаар огт сонсоогүй гэжээ.

#### Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан 30-60 насны нийт 671 эмэгтэйчүүдийн дундах УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлс, ХХВ (папиломавирус)-ийн болон эсийн шинжилгээний талаарх мэдлэг дутмаг байна.
2. Тиймээс эрт илрүүлэг болон дархлаажуулалтад хамрах хүрээг өргөсгөхийн тулд зорилтот бүлгийн хүн амын мэдлэгийг сайжруулах, мэдээллийг бүх шатлалын эмнэлгийн байгууллагаар болон телевиз, тараах материал, зурагт хуудсаар түгээх нь үр дүнтэй юм.

3. Зорилтот бүлгийн хүн амын мэдлэгийг сайжруулах, илрүүлэг шинжилгээнд боловсрол болон амьжиргааны түвшин муу, 50-60 насны, мэргэжлийн эмчид үзүүлж байгаагүй, шинжилгээ хийлгэж байгаагүй эмэгтэйчүүдийг түлхүү анхаарч, хамруулах шаардлагатай байгааг энэхүү судалгаа харуулж байна.

#### Талархал

Энэхүү судалгааг Монголын Мянганы Сорилтын сангийн эрүүл мэндийн төслийн, санхүүгийн дэмжлэгтэй хийсэн болно. Судалгааг явуулахад санал, зөвлөмж өгч, тусалсан АУ-ны Доктор, Проф, ХСҮТөвийн Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн зөвлөх эмч Д.Авирмэд, НЭМХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, АУ-ны доктор И.Болормаа, ЭМЯ-ны Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Я.Буянжаргал, EPOS health management зөвлөх байгууллагын тэтгэлгийн багийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Түүнчлэн судалгаа хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлсэн ХСҮТ-ийн ЭШМС хариуцсан дэд захирал, АУ-ны доктор Г.Пүрэвсүрэн, Клиник эрхэлсэн захирал Г.Навчаа, Туяа эмчилгээний тасгийн эрхлэгч Г. Одонтуяа, их эмч Г.Оюунгэрэл болон тус тасгийн хамт олон; НЭМГазрын НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Н.Болормаа; Ховд, Өвөрхангай, Дорнод аймгийн ЭМГ-ын эх барих эмэгтэйчүүдийн тусламж хариуцсан мэргэжилтэнүүд; “Монголын Эх баригч бага эмч нарын нийгэмлэг”; судалгаанд сонгогдсон эмэгтэйчүүдээ идэвхтэй хамруулсан “Түмэн Эх”, “Мэнд Цолмон”, “Био-Асралт”, “Биваангирд”, “Тэгш Саруул”, “Энх-Ачит”, “Тэрмэстий”, “Орхон Түшээ Мөрөн” өрхийн эмнэлэг; Өвөрхангай аймгийн Хархорин, Хайрхандулаан; Ховд аймгийн Булган, Мөнххайрхан; Дорнод аймгийн Чулуухороот, Матад сумын эмнэлгийн эмч, сувилагч, эх баригч нар болон бидний судалгаанд идэвхтэй оролцсон эмэгтэйчүүддээ талархал илэрхийлье.

#### Ном зүй

1. Ferlay J et al. Globocan 2002. IARC 2004.
2. WHO, Comprehensive Cervical Cancer Control. A guide to essential practice., Geneva, 2006, x.16-17.

3. Luke K. Cervical cancer screening: meeting the needs of minority ethnic women. Br J Cancer 1996; 74 (Suppl. XXIX):S47-50.
4. Cheek J, Fuller J, & Ballantyne A. Vietnamese women and pap smears: issues in promotion. Aust NZ J Public Health 1999;23:72-6.
5. Хорт хавдрын үндэсний хэмжээний тайлан 2000-2009.
6. Erdenechimeg E, Boog J, Nyamkhorol D, Oyuntogos L. Qualitative study on health seeking behavior of women with respect to breast and cervical cancer screening in Ulaanbaatar. 2010
7. Mohammad Siahpush, & Gopal K. Singh, Sociodemographic Predictors of Pap Test Receipt, Currency and Knowledge among Australian Women. J Preventive Medicine 35, 362–368 (2002)
8. Wong L P, Wong Y L, Low W Y, Khoo E M, Shuib R. Knowledge and awareness of cervical cancer and screening among Malaysian women who have never had a Pap smear: a qualitative study. Singapore Med J 2009; 50 (1) : 49
9. Jasmin A. Tiro, Helen I. Meissner, Sarah Kobrin, & Veronica Chollette. What Do Women in the U.S. Know about Human Papillomavirus and Cervical Cancer? J. Cancer Epidemiol Biomarkers Prev 2007;16(2). February 2007

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Анагаах ухааны доктор, профессор  
Д.Авирмэд*